

ДОЛООДУГААР АНГИЙН МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН
ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТ-2024

ХУВИЛБАР А

Хугацаа-60 минут Нийт-20 оноо

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: Эхийг уншаад даалгаврыг гүйцэтгээрэй.

ҮРЖИНГИЙН ЯДАМСҮРЭН

Ядамсүрэн гуайн 1952 онд зурсан алдарт “Өвгөн хуурч” бүтээл нь Дели хотод болсон олон улсын үзэсгэлэнгээс тэргүүн шагнал хүртсэн. “Өвгөн хуурч”-ийг ажиглахад царай төрх, нүд, зовхи, сахал, хурган дотортой дээлийнх нь хээ, буржгар цагаан үсний ширхэг бүрийг маш уран нарийн дүрсэлсэн байдаг.

Ядамсүрэн гуай өөрөө их гоё, ганган хээнцэр, цэвэр цэмцгэр хүн байлаа. Дунд зэргийн нуруутай, өвөлдөө хүрэн өнгийн пүүсүү гадартай, халиу дотортой дээл өмсөн, минжний үсээр эмжсэн дэрвэгэр талтай, оройдоо том сампин зангидаастай өндөр малгай духдуулан явдаг сан.

Гадаадаас ирсэн зураачдыг бид Ядамсүрэн гуайн гэрт дагуулан очиход цагаан өнгийн пансан монгол цамцтай, улаан хүрэн өнгөөр будсан алтан зүмбэртэй модон орон дээрээ судар дэлгэн уншиж суухтай нь олонтаа таарч байлаа.

Түүний уран бүтээлд торгон зураг чухал байр эзэлдэг. “Найрамдал”, “Үндсэн хууль”, “Хангарьд” зэрэг олон бүтээлийг дурдаж болно. Түүний уран бүтээлийн баялаг амьдрал хожмын хойч үедээ үлгэр дуурайл болохын хамт нэг ёсны нэвтэрхий толь болсон юм. Р. Бат – Очир

1. Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олно уу. /2 оноо\

А. “Өвгөн хуурч” зургийн тухай

Б. “Өвгөн хуурч” бүтээл нь Дели хотод болсон олон улсын үзэсгэлэнгээс тэргүүн шагнал хүртсэн тухай

В. Зураач Ядамсүрэнгийн уран бүтээл болон түүний тухай

Г. Түүний уран бүтээлд торгон зураг чухал байр эзэлдэг тухай

2. Дараах энгийн өгүүлбэрүүдийн гол гишүүдийг зурж, ЗНӨ болгон бичээрэй. /2оноо\

Ядамсүрэн гуай өөрөө их гоё, ганган хээнцэр, цэвэр цэмцгэр хүн байлаа. Том сампин зангидаастай өндөр малгай духдуулан явдаг сан.

3. Дараах үгийн утгыг хам орчноос тайлбарлан бичээрэй. /2 оноо/

Сампин

4. ЗНӨ-ийн нөхцөлийг ойролцоо нөхцөлөөр солин найруулаарай. /2оноо/

Гадаадаас ирсэн зураачдыг бид Ядамсүрэн гуайн гэрт дагуулан очиж, цагаан өнгийн пансан монгол цамцтай, улаан хүрэн өнгөөр будсан алтан зүмбэртэй модон орон дээрээ судар дэлгэн уншиж суухтай нь олонтаа таарч байлаа.

5. “Дайчин нөхдөө дурсуулъя” өгүүлбэр дэх үйл үгийг бүтцээр задалж “Ъ” үүргийг тайлбарлаарай. /2оноо\

.....
.....
6. “Шүхэрч Буниа” зохиолын товч агуулгыг бичнэ үү. /5оноо/

.....
.....
.....
.....
.....
.....
7. МОНГОЛ БИЧИГ Өгүүлбэрийг уншаад хөрвүүлж бичээрэй \5оноо

Өвгөн гэгдэх /хүний/ үзэгдэл нь үнэнчлэлтэй.

Хүнийг /хүнийг/ өвгөн гэгдэх /хүнийг/ үзэгдэл нь үнэнчлэлтэй.

Хүнийг /хүнийг/ өвгөн гэгдэх /хүнийг/ үзэгдэл нь үнэнчлэлтэй.

ДОЛООДУГААР АНГИЙН МОНГОЛ ХЭЛ, БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТ-2024

ХУВИЛБАР Б

Хугацаа-60 минут Нийт-20 оноо

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: Эхийг уншаад даалгаврыг гүйцэтгээрэй.

ЦАСАНГАА

Орж гарсан хүүхдүүдийн гар дээр хэд хэдэн чихэр тавьж байтал тэдний ер бусын хүн зогсож байна. Хав хар царайтай, үс нь ширэлдээд, дошны эсгий шиг болчихсон, шагайг нь шүргэсэн өргөн өмд нь урагдаад шилбэ нь цухуйчихсан хөл нь гэж хумстай илүүр л гэсэн үг. Хир даг болчихсон ямбуу цамцны цаанаас үл мэдэгхэн хоёр хөх томбойх нь эмэгтэй хүн болов уу? Тоссон алган дээр нь хэдэн чихэр тавьтал ухаангүй баярлан инээмээр аядахад нь зөрж ургасан хэдэн шар шүд нь ярзайж харагдсан юм. Түүнийг гарахад хүүхдүүд дундаа хийн бужигналдан одлоо.

Ах маань над руу инээмсэглэн харж:

Цасангаа гэдэг юм. “Манай нутгийн мэдрэл муутай хүүхэн дээ” гэж танилцуулсан юм. Ингээд би Цасангаа гэдэг шинэ танилтай боллоо. Тэр маань амьтан хүнд гэм хүргэнээ гэж үгүй. Хаа хамаагүй л хүүхдүүд дагуулчихсан гүйж явдаг юм.

Цасангаагийнх сумын баруун захад нэлээн зайдуу хэсэгхэн унь шовойлгоод, эсгий навтсаар хуччихсан нь эгээ л хомоо туйлчихсан тэмээ гэлтэй. Дотор нь орвол битүү юм дэвсэж, хэсэгхэн газар хонхойлгоод ор болгочихсон, гурван чулуу тавьж дээр нь хөө тортог болсон хар хувин тавиастай, түүнийгээ нэрж усыг нь ууж, тосыг нь долоож амьдардаг юм. Гэхдээ хүмүүс Цасангааг гарандаа нөлөөтэй гэдэг юм. Унасан туссан хүүхдийн толгойг хэд илээд л зүгээр болгочихно. Өвдсөн, зовсон, бэртсэн үедээ л хүмүүс Цасангаа гэж нэг буянтан бий дээ гэдгийг санана. Баярласан хүмүүс аяга хоол, хэдэн чихэр өгөөд л гаргана. Цасангаа баярлаад л гүйж одно доо.

1. Эхийн гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг олоорой. \2 оноо\

А. Тоссон алган дээр нь хэдэн чихэр тавьтал ухаангүй баярлан инээмээр аядахад нь зөрж

ургасан хэдэн шар шүд нь ярзайж харагдсан юм.

Б. . Өвдсөн, зовсон, бэртсэн үедээ л хүмүүс Цасангаа гэж нэг буянтан бий дээ гэдгийг санана.

В. Ингээд би Цасангаа гэдэг шинэ танилтай боллоо.

Г. Баярласан хүмүүс аяга хоол, хэдэн чихэр өгөөд л гаргана. Цасангаа баярлаад л гүйж одно доо.

2. Дараах энгийн өгүүлбэрүүдийн гол гишүүдийг зурж, ЗНӨ болгон бичээрэй. \2оноо\
Ах маань над руу инээмсэглэн харав. “Манай нутгийн мэдрэл муутай хүүхэн дээ” гэж танилцуулсан юм.

3. Дараах үгийн утгыг хам орчноос тайлбарлан бичээрэй. /2 оноо/

Ярзайх

4. ЗНӨ-ийн нөхцөлийг ойролцоо нөхцөлөөр солин найруулаарай. /2оноо/

Тоссон алган дээр нь хэдэн чихэр тавьтал ухаангүй баярлан инээмээр аядахад нь зөрж ургасан хэдэн шар шүд нь ярзайж харагдсан юм.

5. Үгийн бүтцээр задалж, зөв бичгийн дүрмийг тайлбарлаарай. \2оноо\
Баярлуулъя

6. “Цагаан сүүний домог” зохиолын товч агуулгыг бичнэ үү. /5оноо/
.....
.....
.....
.....

7. МОНГОЛ БИЧИГ: Өгүүлбэрийг уншаад хөрвүүлэн бичээрэй. \5 оноо\
.....

ᠪᠠᠶᠠᠷᠠᠯᠠᠰᠠᠨ ᠬᠦᠮᠦᠮᠦᠰᠤ ᠠᠶᠠᠭᠠ ᠬᠣᠯ, ᠬᠡᠳᠡᠨ ᠴᠢᠬᠡᠷ ᠦᠭᠡᠳᠡ ᠯ ᠭᠠᠷᠭᠠᠨᠠ. ᠴᠠᠰᠠᠨᠭᠠᠭᠠ ᠪᠠᠶᠠᠷᠠᠯᠠᠳᠠᠳᠤ ᠯ ᠭᠦᠢᠵᠡ ᠣᠨᠳᠤ ᠳᠣ᠋᠎ᠠ.

ᠲᠣᠰᠰᠣᠨ ᠠᠯᠭᠠᠨ ᠳᠡᠭᠡᠷ ᠨᠢ ᠬᠡᠳᠡᠨ ᠴᠢᠬᠡᠷ ᠲᠠᠪᠦᠲᠠᠯ ᠤᠬᠠᠭᠠᠨᠭᠦᠢ ᠪᠠᠶᠠᠷᠠᠯᠠᠨ ᠢᠨᠡᠭᠡᠮᠡᠭᠡᠷ ᠠᠶᠠᠳᠠᠬᠠᠳᠠ ᠨᠢ ᠵᠦᠷᠵᠢ ᠤᠷᠭᠠᠰᠠᠨ ᠬᠡᠳᠡᠨ ᠶᠠᠷᠵᠠᠢᠵᠢ ᠬᠠᠷᠠᠭᠠᠳᠠᠨ ᠶᠤᠮᠤ.

ᠪᠠᠶᠠᠷᠠᠯᠠᠭᠤᠯᠢᠵᠢᠶᠠ ᠪᠠᠶᠠᠷᠠᠯᠠᠰᠠᠨ ᠬᠦᠮᠦᠮᠦᠰᠤ ᠠᠶᠠᠭᠠ ᠬᠣᠯ, ᠬᠡᠳᠡᠨ ᠴᠢᠬᠡᠷ ᠦᠭᠡᠳᠡ ᠯ ᠭᠠᠷᠭᠠᠨᠠ.